



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 02 03, Факс: (976-11) 32 26 83,  
Цахим шуудан: info@gazar.gov.mn

2024. 11. 27 № 2/0285

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН АЛБА, 21 АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ**

“Газрын харилцааны салбарын шилдгийг шалгаруулах журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор холбогдох бичиг баримтуудыг ирүүлнэ үү.

Хавсралтаар “Газрын харилцааны салбарын шилдгийг шалгаруулах журам”-ыг хүргүүлэв.

Хавсралт...хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЭНХБОЛД

1524022779



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

“Газрын харилцааны салбарын шилдгийг  
шалгаруулах журам” батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын харилцааны салбарын шилдгийг шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг агентлаг, аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны нийт албан хаагчид, сумдын даамлуудад, журмын дагуу салбарын шилдгийг шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/170 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т үүрэг болгосугай.


ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ



Газар зохион байгуулалт, геодези,  
зураг зүйн ерөнхий газрын даргын  
2024 оны 06 дугаар сарын 11-ны  
өдрийн 11/2 дугаар тушаалын хавсралт



## ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ШИЛДГИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Газрын харилцааны салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлж, ажил үүргээ амжилттай хэрэгжүүлсэн хамт олон, менежер, албан хаагчдыг шалгаруулан, идэвх, санаачилга, ажлын амжилтыг үнэлж, алдаршуулах, урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

### Хоёр.Хамрах хүрээ

2.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (цаашид “агентлаг” гэх), аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тэдгээрт ажиллаж буй албан хаагчдад хамаарна.

### Гурав.Шилдгийн төрөл

3.1.Газрын харилцааны салбарын шилдгүүдийг дараах төрлөөр шалгаруулна. Үүнд:


- 3.1.1.Шилдэг байгууллага;
- 3.1.2.Шилдэг нэгж;
- 3.1.3.Шилдэг ажил;
- 3.1.4.Шилдэг менежер;
- 3.1.5.Шилдэг нэгжийн дарга;
- 3.1.6.Шилдэг ажилтан;
- 3.1.7.Шилдэг газрын даамал.

3.2. Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаар “ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА” төрлөөр 5 байгууллагыг;

- 3.2.1.Тэргүүн байр;
- 3.2.2.Дэд байр;
- 3.2.3.Гутгаар байр;
- 3.2.4.Тусгай байр 2.

3.3.Агентлагийн нэгжүүдээс тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаар “ШИЛДЭГ НЭГЖ” төрлөөр 1 нэгжийг;

3.4.Агентлагийн нэгж, аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилд шинээр санаачлан, хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээгээр “ШИЛДЭГ АЖИЛ” төрлөөр 2 ажил, үйлчилгээг;



3.5. Байгууллага, хамт олноо оновчтой удирдан зохион байгуулж, мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллаж, салбарын хэмжээнд гаргасан амжилтаар “ШИЛДЭГ МЕНЕЖЕР” төрлөөр аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын 1 даргыг;

3.6. Байгууллага, хамт олноо оновчтой удирдан зохион байгуулж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж, салбарын хэмжээнд гаргасан амжилтаар “ШИЛДЭГ НЭГЖИЙН ДАРГА” төрлөөр 3 хүртэлх нэгжийн даргыг шалгаруулна. Үүнд:

3.6.1. агентлагийн нэгжийн дарга 1;

3.6.2. аймгийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийн дарга 1;

3.6.3. нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийн дарга эсхүл дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга 1.

3.7. Байгууллагын зорилго, ажлын үр дүнг дээшлүүлэхэд идэвх санаачилга гаргаж, бусдыгаа хошуучилсан амжилтаар “ШИЛДЭГ АЖИЛТАН” төрлөөр 5 ажилтныг;

3.7.1. агентлагийн ахлах мэргэжилтэн 1;

3.7.2. агентлагийн мэргэжилтэн, ажилтан 1;

3.7.3. аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн 1;

3.7.4. аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, ажилтан 2.

3.8. Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэн, идэвх санаачилга гарган, бусдыгаа хошуучилсан амжилтаар “ШИЛДЭГ ГАЗРЫН ДААМАЛ” төрлөөр 5 даамлыг;

### **Дөрөв.Нэр дэвшүүлэх**

4.1. Шилдгийн төрөл тус бүрд дор дурдсанаар нэр дэвшүүлэх бөгөөд энэхүү журмын 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу материалаа бэлтгэн жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор агентлагт ирүүлнэ. Үүнд:

4.1.1. “Шилдэг байгууллага” төрөлд агентлаг аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.2. “Шилдэг нэгж” төрөлд агентлагийн нэгж нэрээ дэвшүүлнэ.

4.1.3. “Шилдэг ажил”-ын төрөлд агентлагийн нэгж, аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн жилд шинээр санаачлан хийсэн ажил, үйлчилгээгээ нэр дэвшүүлнэ.

4.1.4. “Шилдэг менежер” төрлийн “Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга”-д энэхүү журмын 3.1.1-д заасан “Шилдэг байгууллага” төрлөөр эхний 5 байранд шалгарсан байгууллагын даргыг ажлын хэсэг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.5. “Шилдэг нэгжийн дарга”-ын “Агентлагийн нэгжийн дарга” төрөлд нэгжийн дарга нарыг ажлын хэсэг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.6. “Шилдэг нэгжийн дарга”-ын “Аймгийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийн дарга” төрөлд аймгийн газрын асуудал



хариуцсан төрийн захиргааны байгууллага болон “Шилдэг байгууллага” төрөлд эхний 5 байранд шалгарсан байгууллагын нэгжийн даргыг нэр дэвшүүлнэ,

4.1.7.“Шилдэг нэгжийн дарга”-ын “Нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийн дарга” болон “Дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албаны дарга” төрөлд нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дотоод шалгаруулалтыг хийж, шалгарсан нэг нэгжийн даргыг нэр дэвшүүлнэ.

4.1.8.“Шилдэг ажилтан”-ы “Агентлагийн ахлах мэргэжилтэн”, “Агентлагийн мэргэжилтэн, ажилтан” төрөлд агентлагийн нэгж нь төрөл тус бүрд нэг хүртэл тооны албан хаагчийг нэр дэвшүүлнэ.


4.1.9.“Шилдэг ажилтан”-ы “Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн” төрөлд тус бүр 1 хүртэл тооны ахлах мэргэжилтэнг, “Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, ажилтан” төрөлд тус бүр 2 хүртэл тооны албан хаагчийг нэр дэвшүүлнэ.

4.1.10.“Шилдэг газрын даамал”-ын төрөлд аймгийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэг даамлыг нэр дэвшүүлнэ.

### Тав.Шалгуур үзүүлэлт

5.1. Шилдэг хамт олны “Шилдэг байгууллага”, “Шилдэг нэгж” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

| №  | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                              | Шилдэг байгууллага (3.1.1) | Шилдэг нэгж (3.1.2) |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|---------------------|
| 1. | Тухайн оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ (0-50)<br><i>Тайлбар: Шилдэг байгууллага шалгаруулалтад нэр дэвшиж байгаа бол тухайн шатны Засаг даргын Тамгын газрын даргын саналыг харгалзана.</i>               | +                          | +                   |
| 2. | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ (0-10)                                                                                                         | +                          | +                   |
| 3. | Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байдал (0-5)                                                                                                                                 | +                          |                     |
| 4. | Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох чиглэлээр зохион байгуулсан ажил (0-5)                                                                                                                           | +                          |                     |
| 5. | Тухайн онд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн (0-10)<br><i>Тайлбар: Агентлагийн даргын батлагдсан нэгдсэн удирдамжаар тухайн жилд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг тооцно.</i>                   | +                          | +                   |
| 6. | Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байдал (0-5)<br><i>Тайлбар: Тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаатай тайлангууд хамаарна.</i> | +                          | +                   |
| 7. | Санхүүгийн зөрчилгүй байдал (0-10)<br><i>Тайлбар: Тухайн жилийн аудитын дүгнэлтийг үндэслэнэ.</i>                                                                                                             | +                          |                     |
| 8. | Нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн ажил (0-5)                                                                                                                                                        | +                          | +                   |






|    |                                                                                                                  |          |            |         |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|------------|---------|
|    | хийсэн ажил болон албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх талаар авсан арга хэмжээний байдал (0-10) |          |            |         |
| 5. | Санхүүгийн болон сахилга хариуцлагын зөрчилгүй байдал (0-10)                                                     | +        | +          | +       |
| 6. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал (0-10)                        | +        | +          | +       |
|    | Нийт оноо                                                                                                        | 100 оноо | 90<br>оноо | 90 оноо |

#### 5.4. "Шилдэг ажилтан" төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

| №  | Шалгуур үзүүлэлт                                                                                             | Шилдэг ажилтан (3.1.6) |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| 1. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн үнэлгээ (0-50 оноо)                         | +                      |
| 2. | Нэгжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ, санал санаачилга гаргаж хэрэгжүүлсэн байдал (0-10 оноо)    | +                      |
| 3. | Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байдал (0-5 оноо) | +                      |
| 4. | Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт (0-10 оноо)                                                         | +                      |
| 5. | Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал (0-5 оноо)                                            | +                      |
| 6. | Тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын товч танилцуулгыг видео хэлбэрээр ирүүлсэн байдал (0-10 оноо)             | +                      |
| 7. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал (0-10)                    | +                      |
|    | Нийт оноо                                                                                                    | 100 оноо               |

#### 5.5. "Шилдэг газрын даамал" төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

| №  | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                          | Шилдэг газрын даамал (3.1.7) |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|
| 1. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн үнэлгээ (0-50 оноо)                                                                                                                                                                                                      | +                            |
| 2. | Хариуцсан үйл ажиллагаатай холбоотой шинээр санаачилсан ажил, төрийн үйлчилгээг сайжруулах, шуурхай болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажил (0-10 оноо)<br><i>Тайлбар: эрх бүхий байгууллагаар батлуулсан байдал, санхүүжилтийг шийдвэрлэсэн байдал, хэрэгжилтийг зохион байгуулсан байдал</i> | +                            |
| 3. | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал (0-10 оноо)                                                                                                                                                                                                  | +                            |
| 4. | Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байдал (0-5 оноо)                                                                                                                                                                              | +                            |
| 5. | Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал (0-5 оноо)                                                                                                                                                                                                                         | +                            |



|    |                                                                                                  |          |
|----|--------------------------------------------------------------------------------------------------|----------|
| 6. | Тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын товч танилцуулгыг видео хэлбэрээр ирүүлсэн байдал (0-10 оноо) | +        |
| 7. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал (0-10)        | +        |
|    | Нийт оноо                                                                                        | 100 оноо |

### **Зургаа.Шалгаруулалт**

6.1. Агентлагийн даргын тушаалаар шилдгийг шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, шилдгийн төрөл тус бүрт нэр дэвшсэн материал болон нэр дэвшигчийн тавьсан илтгэлийг үндэслэн шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч шалгаруулалтыг зохион байгуулна.

6.2. Ажлын хэсгийг аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, агентлагийн дарга, нэгжийн дарга болон бусад албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна.

6.3. Ажлын хэсгийн гишүүн бүр шилдгийг шалгаруулах шалгуур үзүүлэлтийн дагуу оноог нууцаар өгнө.

6.4. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн хамгийн өндөр 2, хамгийн бага 2 оноог тус тус хасаж, үлдсэн онооны дундаж оноог гаргана. Шилдгийн төрөл тус бүрээр дундаж онооны хамгийн өндөр оноо авсан байгууллага, албан хаагч болон ажлыг журамд заасан тооны хязгаарт багтаан шалгаруулна.

6.5. Шалгаруулалтыг танхим болон цахим хэлбэрээр хослуулан хийнэ.

6.6. Ажлын хэсэг нь материал хүлээн авах хугацаа дууссан өдөр нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргаж, ажлын 3 хоногт багтаан Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн агентлагийн даргын шийдвэрээр баталгаажуулна.

6.7. Шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн материал шалгуур үзүүлэлтийн шаардлага хангаагүй, хугацаа хоцорсон, шилдгийн төрөлд нэр дэвшүүлэх материал ирээгүй бол тухайн төрөлд шалгаруулалт хийхгүй байж болно.

6.8. Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агентлагийн нэгжүүдийн тухайн оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ, агентлагийн албан хаагчдын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн үнэлгээ болон тухайн онд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг захиргааны чиг үүрэг бүхий нэгж нэр дэвшигч тус бүрээр гаргаж ажлын хэсэгт өгнө.


### **Долоо.Бүрдүүлэх материал**

7.1. Агентлаг, аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шилдгийн төрөлд нэр дэвшүүлэхдээ дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

7.1.1. Энэхүү журмын 5.1, 5.3-т заасан төрөлд нэр дэвшүүлсэн бол байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, энэхүү журмын 5.4, 5.5-д заасан төрөлд тухайн албан хаагчийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг тус тус ирүүлнэ.

7.1.2. Энэхүү журмын 7.1.1-д заасан биелэлтээс бусад шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын товч тайланг 3000 тэмдэгтэд багтаан бичиж ирүүлнэ.

7.1.3. Шалгуур үзүүлэлтийн хүрээнд товч тайлангийн хамт фото зураг, бичлэг ирүүлж болох бөгөөд CD болон Flash дээр хуулбарлан ирүүлнэ.



### **Найм.Шагнал, урамшуулал**

8.1. Идэвх санаачилга гаргаж тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаараа шалгарсан шилдэг хамт олон, албан хаагчдад батламж, мөнгөн урамшуулал олгоно.

8.2. “Шилдэг байгууллага”-ын төрлийг дараах байдлаар шагнаж, урамшуулна.

8.2.1. “Шилдэг байгууллага” Тэргүүн байр “Батламж”, 5.000.000 төгрөг;

8.2.2. “Шилдэг байгууллага” Дэд байр “Батламж”, 4.000.000 төгрөг;

8.2.3. “Шилдэг байгууллага” Гутгаар байр “Батламж”, 3.000.000 төгрөг;

8.2.4. “Шилдэг байгууллага” Тусгай байр тус бүр “Батламж”, 2.000.000 төгрөг;

8.3. Агентлагийн “Шилдэг нэгж” “Батламж”, 2.000.000 төгрөг;

8.4. “Шилдэг ажил” тус бүр “Батламж”, 1.000.000 төгрөг;

8.5. “Шилдэг менежер” “Өргөмжлөл”, 1.000.000 төгрөг;

8.6. “Шилдэг нэгжийн дарга” тус бүр “Өргөмжлөл”, 1.000.000 төгрөг;

8.7. “Шилдэг ажилтан” тус бүр “Өргөмжлөл”, 1.000.000 төгрөг;

8.8. “Шилдэг газрын даамал” тус бүр “Өргөмжлөл”, 1.000.000 төгрөг.

### **Ес.Шилдгийн шагнал гардуулах**

9.1. Агентлагийн “Шилдэг нэгж”, “Шилдэг нэгжийн дарга”, “Шилдэг ажилтан”-ы шагналыг агентлагийн Шинэ жилийн баярын арга хэмжээн дээр гардуулна.

9.2. Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Шилдэг байгууллага”, “Шилдэг ажил”, “Шилдэг менежер”, “Шилдэг нэгжийн дарга”, “Шилдэг ажилтан”, “Шилдэг газрын даамал”-ын шагналыг жил бүрийн газрын харилцааны салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн дээр гардуулна.

9.3. Шилдгүүдийг алдаршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг агентлагийн захиргааны чиг үүрэг бүхий нэгж зохион байгуулна.

\_\_оОо\_\_

